


ӨВӨЛЖИЛТ ХҮНДЭРСЭН, ЗУДТАЙ ЖИЛҮҮДЭД ЭРЭГТЭЙ МАЛЧДЫН ӨДӨР ТУТМЫН АЖЛЫН АЧААЛАЛ НЭМЭГДДЭГ.

DURING HARSH WINTERS, THE DAILY WORKLOAD OF MALE HERDERS INCREASES.



“Эрэгтэй малчдын хувьд эмэгтэй малчидтай харьцуулахад өвлийн цагт өдөр тутамдаа хийж байгаа ажлууд нь төрлийн хувьд цөөн боловч ихэвчлэн гэрээс гадуур, олон цагаар хийх шаардлагатай ажлууд байдаг. Өвөлжилт хүндэрсэн, зудын нөхцөл байдалтай жилүүдэд отроор гэрээс хол, гадаа хүйтэнд, олон цагаар, хоол хүнс муутай ажиллах, биеийн хүчний ажлыг цөөн хүн хүчээр хийх шаардлага үүсдэг. Байгалийн гамшигт үзэгдлийн үед ганцаараа хүчгүйдэх, мал сүргээ эрэх хайх, малтайгаа шуурга уруудах, төөрөх зэргээр амь нас, эрүүл мэндийн хувьд ч аюулд орох эрсдэлтэй.

“For male herders, compared to female herders, the types of tasks they carry out on a daily basis during winter are fewer, but these tasks are mostly conducted outside the home and require long hours. In years when wintering conditions are severe and there is a risk of зуд (a natural disaster involving heavy snow or extreme cold), men often have to work far from home, outdoors in the cold for extended periods, with limited food and under physically demanding conditions, often with minimal manpower. During natural disasters, they are at high risk of physical harm or even loss of life due to exhaustion, getting lost while searching for livestock, or being caught in snowstorms while herding animals downhill.